

XANADU MINES

ЗАНАДУ МАЙНЗ

Тогтвортой байдлын тайлан **2020**



УРЬДЧИЛСАН МЭДЭГДЭЛ

Энэхүү тайлан нь компанийн туршлага, үзэл санаанд тулгуурлан хийгдсэн дүн шинжилгээ, таамаглалд үндэслэн боловсруулсан хэтийн зорилгыг агуулна. Тус тайланд тусгасан төлөвлөгөөт зорилго, зорилтууд нь ашигт малтмалын нөөц, олборлолтын хувь хэмжээ тооцоолол, олборлолт ба үнэ, нөхөн сэргээх зардал ба үр дүн, хөрөнгийн зарцуулалт, мөн ирээдүйд гарч болзошгүй чухал эрсдлүүд, тодорхойгүй байдал, таамаглал болон бусад Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц урьдчилан таамаглах боломжгүй хүндрэлүүдээс хамааралтай ба ирээдүйн техник, нийгэм, эдийн засаг, зах зээл, улс төрийн болон бусад хүчин зүйлсийг үндэслэсэн болно. Эдгээр зорилго зорилтуудыг Занаду компанийн хийсэн судалгаа таамаглалд суурьлан техникийн, бизнес, эдийн засаг, зах зээлийн өрсөлдөөн, улс төр, нийгмийн тодорхойгүй байдал, гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал, мэдэгдэж байгаа болон үл мэдэгдэх эрсдэл, тодорхой бус байдалд хийсэн дүгнэлт дүн шинжилгээ тооцоолол, таамаглалд үндэслэсэн хэдийч бодит байдал, үр дүн нь урьдчилан тус тайланд тусгагдсанаас эсвэл хүлээгдэж буй үйл явдал, үр дүнгээс зөрүүтэй байхыг үгүйсгэхгүй. Итгэх, хүлээх, урьдчилан таамаглах, илтгэх, тунгаах, төлөвлөгөө зорилт, төлөвлөх, зорих, үргэлжлүүлэх, төсөвлөх, тооцоолох, магадгүй, хуваарилж төлөвлөх гэх мэт ирээдүйг харсан тодорхойлох үгсийг энэхүү мэдэгдэлд ашиглав. Энэхүү тайлангийн агуулга нь тайлан боловсруулагдсан цаг хугацааг илтгэх бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд Компани нь ирээдүйд болох үйл явдал, шинэ мэдээллийн үр дүнд хэтийн төлөвтэй холбоотой аливаа мэдээллийг шинэчлэх, засварлах, үүрэг хариуцлага хүлээгээгүй болно.



Энэхүү тайланд

03

ТУЗ-ийн Даргын
мэндчилгээ

20

Тогтвортой байдлын
засаглал

42

Байгаль орчноо
хайрлан хамгаалах

06

Компанийн
тухай

29

Тогтвортой байдлын
тогтолцоо

48

Орон нутгийн
иргэдийг дэмжих

13

Бидний үнэт
зүйлс

32

Уур амьсгалын
өөрчлөлт

55

Байгууллагын
удирдлага

14

Тайлангийн
тухай

38

Аюулгүй ажлын
байрыг дэмжих





ТУЗ-ийн Даргын МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм уншигч танаа,

Занаду Майнз компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс анхны Тогтвортой байдлын тайлангаа танилцуулж байгаадаа таатай байна.

Бид хайгуул, бүтээн байгуулалтын бизнест тогтвортой байдлыг хангахад улам ихээр анхаарал хандуулж, ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл энэ тайлан болсон ба энэ нь Занаду компанийн Хармагтай, Улаан Уул төсөл зэрэг дэлхийн томоохон зэсийн дүүргүүдэд онцгой ач холбогдолтой юм.

Төсөл хэрэгжүүлэгчид үйл ажиллагаа явуулахдаа олон нийт, нийгмийн байнгын дэмжлэгийг авахын тулд тогтвортой байдлын зарчмуудыг хэрэгжүүлэн ажиллах ёстой. Энэ нь засгийн газар, олон нийт, хөрөнгийн зах зээлд хариуцлагатай байгууллага гэдгээ харуулж, бидний үйл ажиллагаа иргэдэд болон хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлдгийг ойлгож ажиллана гэсэн үг юм.

Уул уурхайн хөгжлийн эхэн үе шатанд тогтвортой байдлын тухай ойлголтыг хэрэгжүүлэн хэвшүүлэх нь цаашдын уул уурхайн цогц үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үндэс гэж бид итгэдэг. Иймд бид одоогийн үйл ажиллагаа болон төслүүдээ хөгжлийн дараагийн шатанд шилжүүлэхийн тулд эдгээр систем, суурь үзүүлэлтүүдийг одоо бүрдүүлж байна.

Хүндэтгэсэн,

Колин Мурхед

ТУЗ-ийн Дарга



Гүйцэтгэх захирлын МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм уншигч танаа,

Компанийнхаа үнэт зүйлс, аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай хайгуулын салбарт тэргүүлэгч байх зорилго дээр суурилсан 2020 оны Тогтвортой байдлын тайлангаа танилцуулж байгаадаа Занаду компаний удирдлага бид баяртай байна.

Энэхүү тайлан нь бидний тогтвортой байдлын тухай ойлголт зөв зүйл хийх гэсэн өнөөгийн суурь үзэл баримтлалаас бизнес үйл ажиллагаандаа илүү нэгдмэл, тогтвортой байдлаар хандахад чиглэн өөрчлөгдөж байгааг илтгэж байна.

Занаду компани COVID-19 цар тахлын үед үйл ажиллагааны тасалдал багатайгаар аюулгүй, үр дүнтэй ажилласныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь бид тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр зарим томоохон үр дүнд хүрснийг онцолж байна:

- Манай ажилчид болон тэдний гэр бүлийнхэнд зориулсан дархлаажуулалтыг дэмжих эрүүл мэнд, аюулгүй байдлын хөтөлбөрүүд;
- Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хангамжийн менежмент, тусгаарлалт, хорио цээрийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн;
- Хүний хөгжлийн бодлого үр дүнтэй. 100% Монгол баг хамт олонтой, урт хугацааны туршид аюулгүй, бие даан ажиллах ур чадвартай баг хамт олон.

Говийн нутаг дэвсгэрт оршин суугч иргэдтэй харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэн хадгалах, гүний цэвэр ус ашиглалт, орон нутгийн жижиг бизнесүүдийг дэмжих, эрүүл мэндийн болон боловсролын чиглэлээр туслалцаа дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Төслүүд нэмүү өртгийн сүлжээгээр үйлдвэрлэлд шилжиж байгаа тул Занаду байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг сайжруулахын тулд технологийн дэвшлийг ашиглаж байна.

Жишээлбэл, Хармагтай төслийн судалгаанд эрчим хүч, байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эрсдлийг багасгах орчин үеийн малталт, боловсруулах байгууламжийн техник эдийн засгийн үнэлгээг боловсруулж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд байнгын хувь нэмрээ оруулдаг ажилтнууд, гүйцэтгэгчид, түншүүддээ талархал илэрхийлж байна. Мөн цаашдын тогтвортой байдлыг хангах манай үйл ажиллагааны дараагийн алхмыг хамтдаа хийхийг тэсэн ядан хүлээж байна.

Хүндэтгэсэн,

Др Эндрю Стюарт

Ерөнхий захирал, Гүйцэтгэх захирал



“

Энэхүү тайлан нь бидний тогтвортой байдлын тухай ойлголт зөв зүйл хийх гэсэн өнөөгийн суурь үзэл баримтлалаас бизнес үйл ажиллагаандаа илүү нэгдмэл, тогтвортой байдлаар хандахад чиглэн өөрчлөгдөж байгааг илтгэж байна.



An aerial photograph of a mining facility, likely a porphyry copper-gold mine, situated in a vast, arid desert landscape. The facility includes several large storage tanks, processing buildings, and infrastructure. The terrain is characterized by rolling sand dunes and dry riverbeds. The sky is a mix of blue and orange, suggesting a sunset or sunrise. The text is overlaid on the upper portion of the image.

**Занаду Майнз Лимитед
нь дэлхийн хэмжээнд
ач холбогдолтой
порфир зэс-алтны
ордуудыг Монгол
Улсад нээн илрүүлж,
тогтоодог хайгуулын
компани юм.**

Бид хямд өртгөөр нээлт хийх,
нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор
эх орондоо бий болгосон
туршлага, харилцаа холбоог
ашигладаг.



Компанийн тухай

Монгол улсад эзлэх бидний байр суурь нь дараах байдлаар бидний стратегийн давуу тал юм:

- **Хамрах хүрээ:** Дэлхий дахинд чухал ач холбогдолтой, бүрэн судлагдаагүй олон нээлтүүдтэй,
- **Байршил:** Япон, Өмнөд Солонгос, Хятад зэрэг орны зэс хайлуулах үйлдвэрүүдтэй ойр, газар нутаг ихтэй, хүн ам сийрэг.
- **Дэд бүтэц:** Цахилгаан эрчим хүч, авто зам, төмөр зам, усан хангамжийн сүлжээг төслийн талбайн орчинд бий болгосон нь богино хугацаанд үйлдвэрлэлд шилжих боломж олгож, капитал хөрөнгө оруулалт хийх шаардлагыг бууруулдаг.
- **Уул уурхайн боловсрол, соёл:** ДНБ-ий 23%, экспортын орлогын 70%-ийг уул уурхай эзэлдэг, үндэсний ажиллах хүчинд 40,000-аас дээш Монгол уул уурхайн мэргэжилтэн байдаг тул өөрийн орны уул уурхайн томоохон туршлагаас суралцах чадвартай тухай МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулиас мэдээлсэн байна.
- **Өрсөлдөхүйц хууль, эрх зүйн орчин:** Уул уурхайн олон улсын хөрөнгө оруулалтын гэрээнүүд.
- **Тогтвортой, ардчилсан:** Ардчилсан сонгуулийн 30 жилийн түүхтэй.

¹ Хөрөнгө оруулалтын мониторинг, Уул уурхайн эмзэг байдлын индекс 2021-д тусгагдсан байгаагаас харахад уул уурхайн уналтад хамгийн их хохирол амсах орнуудын тоонд Монгол, Австрали улсууд орсон байна.



ҮНДСЭН БОЛОН ГЭРЭЭТ АЖИЛТНУУД


Занаду компанийг орд нээн илрүүлж, үнэ цэнийг бий болгож чадсан туршлагатай хайгуул, олборлолтын мэргэжилтнүүдээс бүрдсэн чадварлаг баг удирддаг

Бид дараах замаар хувьцаа ЭЗЭМШИГЧИДДЭЭ баялаг, үнэ ЦЭНИЙГ бий болгодог:

Монгол Улсад томоохон
хэмжээний зэс-алтны
ордуудыг нээн илрүүлэх,

Нээлт илрүүлэлтийг
хямд өртгөөр хийх,
нөөцийн өсөлтийг
хангах,

Төслүүдийг
нээж илрүүлэн
урьдчилсан ТЭЗҮ
боловсруулах



Зураг 1: Монгол орны эрдэсжилт өндөртэй, бүрэн судлагдаагүй ашигт малтмалын бүс нутагт байрших Занаду компанийн зэс-алтны төслүүдийн байршил


Занаду компанийн Монгол дахь төслүүд:

Хармагтайн Дүүрэг (Занаду компани 76.5%)

Хармагтайн орд нь дэлхийн хэмжээний зэс, алтны томоохон орд бөгөөд олборлолт хийгдээгүй байгаа юм. Хармагтай нь Өмнөговь аймгийн нутагт, Улаанбаатар хотоос зүүн урагш 420 орчим км, Рио Тинто компанийн мэдэлд байдаг Оюутолгойн ордоос хойд зүгт 120 км зайд байрлах маш их ирээдүйтэй зэс-алтны порфирийн дүүрэг юм.

Хармагтайд гурван төрлийн эрдэсжилт байдаг; порфир маягийн штокверк Cu-Au эрдэсжилт, турмалин брекчи маягийн Cu-Au эрдэсжилт ба карбонат өнгөт металлын судалтай холбоотой эпитеpmаль алт. Хармагтайн орд одоогоор 2.6 сая тонн зэсийн эквивалент (1.9 сая тонн зэс, 4.3 сая унц алт) агуулсан 600 сая тонн буюу ЖОРК стандартын шаардлагад нийцсэн ашигт малтмалын нөөцтэй байгаа бөгөөд ордын нөөцийг нэмэгдүүлэх идэвхтэй эрэл хайгуулын ажил хийж байна².

2 ASX/TSX 2018 оны 10-р сарын 31 өдрийн мэдээ – Хармагтайн ил уурхайн нөөц 1.9 сая тонн зэс, 4.3 сая унц алт болж нэмэгдэв.



Улаан уулын дүүрэг (Занаду компани 90%)

Улаан уулын зэс-алтны дүүрэг нь Монгол улсын өмнөд хэсэгт орших Дорноговь аймгийн нутагт, Сайншанд хотоос баруун тийш 70 орчим километрийн зайд оршдог. Улаан уул төсөл нь 40 орчим хавтгай дөрвөлжин километр талбайг эзэлдэг маш ирээдүйтэй, бүрэн судлагдаагүй порфирийн зэс-алтны дүүрэг юм. Тус дүүрэгт хэд хэдэн ижил гарал үүсэлтэй порфирийн зэс-алтны хуримтлалууд, эрдэсжсэн турмалин брекчи хоолой ба зэс-алт/өнгөт металл агуулсан магнетиттай скарнуудаас бүрддэг.



Технологийн хөгжил, дэвшил

Занаду компани нь тогтвортой байдалд үзүүлэх хор нөлөөг багасгах, салбарынхаа тэргүүлэгч байхын тулд орчин үеийн дэвшилтэт хайгуулын арга, техник технологийг ашиглахыг эрмэлздэг.

Үүнд орчин үеийн геофизикийн судалгааны багаж хэрэгслийг ашиглан зорилгуудаа илүү сайн тодорхойлж, өрмийн цооногийн тоо, эрчим хүч, хүний нөөцийн зарцуулалтыг багасгах зэрэг болно.

Өрөмдлөгийн ажил эхэлмэгц, өрмийн цооног бүрээс хамгийн их хэмжээний өгөгдлийг гарган авахын тулд Занаду нь олон спектрт чөмгөн дээжний сканнерын дэвшилтэт технологийг ашигладаг. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, химийн найрлага, геологийн бүтэц, геотехникийн болон геометаллургийн шинж чанарыг тодорхойлох үүднээс хиймэл оюун ухаан,

машин сургалтыг мөн ашигладаг болно. Энэхүү шинжилгээ нь өрөмдлөгийн ажлыг багасгаж, тогтвортой байдалд хамгийн бага нөлөө үзүүлэх хэлбэрээр, үр дүнтэй хайгуул хийх боломжийг олгодог.

Занаду компани хайгуулын төслүүдээ хайхаас эхлээд нарийвчилсан судалгааны үе шат хүртэл хөгжүүлэх явцад аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, үр дүнг оновчтой болгох орчин үеийн, өндөр бүтээмжтэй технологи ашигласнаар ирээдүйн орчин үеийн үр бүтээлтэй уурхайг хөгжүүлэх боломжийг бий болгохыг зорьдог.



Бидний ҮНЭТ ЗҮЙЛС

Занаду компанийн Удирдах зөвлөл нь компанийн зорилгыг биелүүлэхэд захирлууд, удирдах албан тушаалтнууд, ажилчдаас ажлын арга барил, стандартыг тогтоож, Занаду компанийн үндсэн зарчмууд болох Үнэт зүйлсийг тодорхойлсон.

Занаду компанийн үнэт зүйлс нь зорилгоо биелүүлэх, зорилгодоо хүрэхийн тулд Удирдах зөвлөл, захирлууд, удирдах албан тушаалтнууд болон ажилчдаас хүлээх стандарт, арга барилыг тогтоох замаар Компанийн зорилго болон стратегийн зорилтуудын хоорондын уялдаа холбоог бий болгодог.

Бидний ажлыг чиглүүлдэг таван үнэт зүйлс:



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Бид Монгол улсад бүх талын хамтын түншлэлд хариуцлагатай, сайн хамтрагчид юм. Бид баг хамт олноо аюулгүй байлгах, хүрээлэн буй орчныг хамгаалах, үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн ард иргэдийг дэмжих замаар ажилладаг.



ҮНЭНЧ ШУДАРГА БАЙДАЛ

Бидний хувьд компанийн нэр хүнд хамгаас эрхэм юм.



ШИНЖЛЭХ УХААНЧ БАЙДАЛ

Бид бүх үйл ажиллагаагаа шинжлэх ухаанд суурилан явуулдаг.



ЗАРЧИМЧ ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

Бид богино хугацааны ашиг орлогоос илүү урт хугацааны үнэ цэнийг чухалчлан өөриймсгөөр ажилладаг.



КОМПАНИЙН СОЁЛ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Бид техникийн дэвшил, инновацийг эрхэмлэдэг бөгөөд бүх түвшний ажлын байранд шилдэг хүмүүсийг татаж, авч үлдэхийг зорьдог.

Бид бие биендээ үнэнч байж, хариуцлагатай хандах, өдөр бүр үнэт зүйлсээ тууштай хэрэгжүүлэхэд үлгэр дуурайлал үзүүлж, бие биеэ дэмжиж ажилладаг.

Энэхүү тайлан нь Занаду компанийн анхны Тогтвортой байдлын тайлан бөгөөд бидний байгаль орчинд нөлөөлөх байдал, нийгэмд үзүүлэх нөлөө, компанийн засаглалыг тодорхойлох ирээдүйн тайлангийн жишиг үзүүлэлт юм.

Тогтвортой байдлын зарчмуудыг уул уурхайн үйл ажиллагааны бүх үе шатанд тусгах ёстой гэж бид үзэж, хайгуулын компанийн хувьд энэхүү сэтгэлгээг удирдан чиглүүлэхийг зорьдог.




Тайлангийн тухай

Энэхүү тайланд Занаду компанийн 2020 оны үйл ажиллагааг тусгасан болно. (2020 оны 1 сарын 1-ээс 2020 оны 12 сарын 31).

Австралийн Хөрөнгийн Бирж (ASX/АХБ)-д бүртгэлтэй компанийн хувьд бид АХБ-ийн Компанийн засаглалын зарчим, зөвлөмжийг авч хэрэгжүүлэн, ирэх жилүүдэд энэ мэдээллийн талаар үе шаттайгаар тайлагнах зорилгоор салбарын зарчим, тогтолцоог (GRI стандартууд болон ICMM-ийн Тогтвортой хөгжлийн тогтолцоо гэх мэт) хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд бид уг тайлангийн хамрах хүрээг тодорхойлохын тулд анхны материаллаг байдлын үнэлгээг хийлээ. Бид

Занаду компанийн хувьд болон гол оролцогч талуудад тогтвортой байдлыг хангахад хамгийн чухал хүчин зүйлсийг тодорхойлж, эрэмбэлэхэд туслах таван хэсэг бүхий материаллаг байдлын тест, Хариуцлагын тогтолцоог боловсруулан баталсан. Манай гол оролцогч талуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх хэсгээс үзнэ үү.



Зураг 2: Хариуцлагын таван хэсэг бүхий материаллаг байдлын тест

Судалгаа:

Материаллаг байдлыг боловсруулахын тулд хэд хэдэн зүйлсийг судалсан. Үүнд, компанийн дотоодын баримт бичгүүд (бодлогын баримт бичгүүд, эрсдлийн бүртгэл гэх мэт), хэвлэл мэдээлэл, харьцуулсан судалгаа болон дотоодын оролцогч талуудын хэлэлцүүлэг хамаарна.

Эрэмбэлэх:

Судалгааны үр дүнг нэгтгэн цэгцэлж, хамгийн гол эрсдлүүдийг тодорхойлон эрсдлийн матрицад эрэмбэлсэн (Зураг 3).

Батлах:

Тодорхойлсон эрсдлүүдийг баталгаажуулах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулан хамгийн чухал эрсдэлүүдийг энэхүү тайланд тусгав.



Зураг 3: Занаду компанийн бизнест болон оролцогч талуудад хамгийн чухал ач холбогдолтой тогтвортой байдлын эрсдлийн үнэлгээний матриц.



Занаду компанийн хамгийн чухал материаллаг асуудлуудыг хамгийн тохиромжтой гэж үзсэн Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан доор жагсаав.

ӨНДӨР МАТЕРИАЛЛАГ ЭРСДЭЛ	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ	ХУУДАС
Бизнесийг ёс зүйтэй, ил тод байдлаар явуулах	16 PEACE, JUSTICE AND STRONG INSTITUTIONS Энх тайван, шударга ёсыг цогцлоох	26
Уур амьсг алын өөрчлөлт	13 CLIMATE ACTION Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	32
Эрүүл мэнд, аюулгүй байдал	3 GOOD HEALTH AND WELL-BEING Эрүүл мэндийг дэмжих 8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	38
Хүрээлэн буй орчны менежмент	6 CLEAN WATER AND SANITATION Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах 15 LIFE ON LAND Хуурай газрын эко системийг хамгаалах	42
Усны менежмент	6 CLEAN WATER AND SANITATION Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	44
Хөрсний болон биологийн төрөл зүйлийн нөлөөлөл	15 LIFE ON LAND Хуурай газрын эко системийг хамгаалах	46
Орон нутгийн иргэдийг дэмжих, хамтран ажиллах	3 GOOD HEALTH AND WELL-BEING Эрүүл мэндийг дэмжих 4 QUALITY EDUCATION Чанартай боловсролыг дэмжих 6 CLEAN WATER AND SANITATION Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах 8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	50
Орон нутгийн иргэдийн хөгжил, хөрөнгө оруулалт	11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	52

Table 1: Xanadu's material issues of highest importance for 2020.

Оролцогч талуудын хамтын ажиллагаа

**Гол оролцогч талуудтай
хамтран ажиллах нь
бидний болон бидний
бизнесээр дамжуулан
амьжиргаагаа
дээшлүүлдэг иргэдэд
баталгаа болдог.**

**Бид хамтын ажиллагааны ач холбогдлыг
чухалчлан, харилцан ашигтай үр дүнд хүрэхийн
тулд нээлттэй, шударга яриа хэлцэл хийж,
бусдын үзэл бодлыг хүндэтгэн харилцаагаа
хөгжүүлэх, сайжруулахыг хичээн ажилладаг.**

Занаду компани нь гол оролцогч талуудыг өргөн хүрээнд хүртээмжтэй оролцуулдаг. Тайлангийн хугацаанд эдгээр талуудыг болон тэдний сонирхсон салбаруудыг хэрхэн яаж оролцуулсаныг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Бид эдгээр талуудын харилцааг хөгжүүлэх, хадгалах үүрэг хариуцсан ажилтнуудтай. Манай бизнесийн онцлог, төслийн байршлын онцлогтой холбоотойгоор тухайн орон нутгийн иргэд болон төр захиргааны байгууллагуудтай санал бодлоо харилцан ойлголцож, өөрсдийн үйл ажиллагааныхаа талаар үнэн бодит мэдээлэл өгөхийн тулд онцгой анхаарал хандуулдаг.



ОРОЛЦОГЧ ТАЛУУД, БҮЛГҮҮД	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТӨРӨЛ	ХАМТЫН АЖИЛЛАГАА	ХАМРАХ САЛБАР
Хувь эзэмшигчид	Хувь эзэмшигчид, шинжээчид	- Улирлын, жилийн болон хагас жилийн санхүүгийн тайлан - Вэб хуудас, и-мэйл, хөрөнгө оруулагчдын мэдээлэл, нүүр тулсан/ биечилсэн уулзалтууд - Зах зээлийн мэдээлэл - Жил тутмын ерөнхий уулзалт - Салбарын хурал - Биечилсэн уулзалт	- Аюулгүй ажиллагааны гүйцэтгэл - Хайгуулын ажлын үр дүн - Хөгжлийн төлөвлөгөө - Гүйцэтгэлийн үнэлгээ - Орон нутгийн харилцаа хамтын ажиллагаа - Санхүүгийн гүйцэтгэл - Хувьцааны үнэ
Үндсэн болон гэрээт ажилчид	Удирдлага, үндсэн болон гэрээт ажилчид	- Ажилтнуудын мэдээлэл, - И-мэйл, олон нийтийн арга хэмжээ, мэдээллийн самбар, ажлын зааварчилгааны уулзалт, ажлын гүйцэтгэлийн уулзалт, - Нийтийн уулзалт - Шүгэл үлээх үйлчилгээ - Удирдлага ажилтнууд, багийн шууд харилцаа	- Үйл ажиллагааны гүйцэтгэл - Аюулгүй байдал, байгаль орчны биелэлт - Ажилтны оролцоо - Ажилтны хувь хүний хөгжлийн боломжууд
Орон нутгийн иргэд	Орон нутгийн иргэд, олон нийт, газар эзэмшигчид	- Орон нутгийн харилцаа хариуцсан багийн томилолт - Орон нутгийн иргэдтэй хийх уулзалт - Сайт аялал - Орон нутгийн иргэдийн санал сэтгэгдлийг удирдлагад тогтмол танилцуулах - Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа	- Орон нутгийн иргэдтэй хамтын ажиллагаа, үзүүлэх нөлөө - Хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлын судалгаа - Орон нутгийн дэд бүтэц, жижиг бизнест хувь нэмэр оруулах - Газар ашиглалт
Ханган нийлүүлэгчид	Орон нутгийн болон орон нутгийн бус ханган нийлүүлэгчид	- Зах зээлд тулгуурласан арга барил - Нээлттэй, нүүр тулсан шууд харилцаа, хамтын ажиллагаа - Гүйцэтгэлийн тогтмол уулзалт - Гэрээ хэлцэл	- Урт хугацааны хамтын ажиллагаа - Орчин үеийн боолчлолоос ангид нийлүүлэлт
Засгийн газар	Монголын үндэсний, бүс нутгийн, орон нутгийн төрийн байгууллага, Австралийн засгийн газар	- Нээлттэй, нүүр тулсан шууд харилцаа, хамтын ажиллагаа - Жилийн эцсийн тайлан, вэб хуудас, и-мэйл, гомдол санал, аудитын шалгалт - Зохицуулалтыг хангах, хэрэгжүүлэх - Орон нутгийн чухал асуудлуудад шууд харилцан хамтран ажиллах - Салбарын удирдлагын оролцоо	- Роялти, тусгай зөвшөөрлийн төлбөр - Аюулгүй ажиллагааны гүйцэтгэл - Ажил олголт - Хууль эрхзүй, зохицуулалтын шинэчлэл сайжруулалт - Байгаль орчны удирдлага, нөхөн сэргээлт
Салбар	Уул уурхай, хайгуулын салбар, бизнесийн болон мэргэжлийн байгууллага, холбоо, орон нутгийн болон бүс нутгийн бизнесийн байгууллага, холбоод	- Уул уурхай, хайгуулын чухал асуудлууд бодлогын талаарх уулзалт, хэлэлцүүлэг, тайлан - Тайлан, нүүр тулсан биечилсэн уулзалтууд, танилцуулга, хамтын ажиллагааны гэрээ хэлцэл	- Хүрээлэн буй орчны нөлөөлөл, - Аюулгүй ажиллагааны гүйцэтгэл - Сэтгэлзүйн эрүүл мэнд
Төрийн бус байгууллага	Байгаль орчны, орон нутгийн иргэдийн, уул уурхайн салбарын	- Уулзалт, и-мэйл - Хамтын ажиллагааны боломжийг эрж хайх	- Орон нутгийн иргэд болон байгаль орчин, хүрээлэн буй орчны нөлөөлөл - Авлигагүй, нээлттэй ил тод төлбөр тооцоолол
Боловсрол	Дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагууд	- Хуралд оролцох - Уулзалт, тайлан, биечилсэн хэлэлцүүлэг	Орон нутгийн иргэдийг сурч боловсрох боломжийг дэмжих

Хүснэгт 2: Занаду компанийн 2020 оны тайлангийн хугацаанд оролцогч талууд, бүлгүүдтэй хамтын ажиллагаа, хамрах салбарууд.

Тогтвортой байдлын засаглал

**Занаду компанийн
Төлөөлөн Удирдах
Зөвлөл нь Аюулгүй
ажиллагаа, эрүүл мэнд,
байгаль орчны багуудаар
дамжуулан тогтвортой
байдлын ажлын
гүйцэтгэлийг тогтмол
хянадаг.**

**Хорооны тогтмол уулзалтаар дараах
асуудлыг хэлэлцдэг:**


- Занаду компанийн үйл ажиллагаа явагдаж буй талбайд ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчны талаар нэн тэргүүнд тавихад чиглэсэн журмууд;
- Занаду компанийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэрт ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, хууль эрх зүй, зохицуулалтын бүх шаардлагыг дагаж мөрдөхөд туслах журмууд;
- Олон нийтийн харилцааг зохицуулах журмууд;
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчинд бодит болон болзошгүй осол, зөрчил, ослын талаар мэдээлэх системийн хүрэлцээтэй байдал;

- Удирдлагын зүгээс хэрэгжүүлдэг аюулгүй байдлын дараагийн шатны шалгалт, засч залруулах арга хэмжээ;
- Удирдах зөвлөлийн баталсан зорилго, гүйцэтгэлийг харьцуулах;
- Занаду компанийн үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн амьжиргааны түвшин доогуур иргэдэд туслах боломжууд.

Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны хорооноос гаргасан дүрэм журмын хуулбарыг манай www.xanadumines.com вэбсайтаас авах боломжтой.

Аудит, эрсдлийн хороо нь Удирдах зөвлөлд боломжит эсвэл илэрхий бизнес, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн тогтвортой байдал болон бусад санхүүгийн бус эрсдэлүүдийг тодорхойлох, удирдахад тусалдаг.

Тус хороо нь мөн Занаду компанийн байгаль орчны эрсдлийн удирдлага, ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын хэрэгжилт үйл явцыг хянадаг. Дүрмийг www.xanadumines.com вэбсайтаас үзнэ үү.



Зураг 4: Занаду компанийн тогтвортой байдлын засаглалын бүтэц.

Занаду компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны гишүүд:



Колин Мурхед

Хараат бус ТУЗ-ийн дарга
(B.Sc (Hons) FAusIMM (CP) GAICD)



Эндрью Стюарт

Ерөнхий захирал,
Гүйцэтгэх захирал
(BSc, PhD, MAIG & MSEG)



Ганбаяр Лхагвасүрэн

Монгол дахь Ерөнхий захирал
(M.IBL)



Мишэл Мусило

ТУЗ-ийн хараат бус гишүүн,
захирал
(LL.B)



Тони Пирсон

ТУЗ-ийн хараат бус
гишүүн, захирал
(B.Com, MAICD)

Гүйцэтгэх бус бүх ТУЗ-ийн гишүүд Удирдах зөвлөлийн дэд хороонд хамаарна.
Занаду компанийн захирлууд болон гүйцэтгэх ажилтнуудын талаарх дэлгэрэнгүй
мэдээллийг www.xanadumines.com сайтаас үзнэ үү.



Бидний тогтвортой байдлын баримтлах зарчим

Занаду компани нь тогтвортой хайгуулын шилдэг компани байхыг эрмэлздэг.

Зорилгодоо хүрэхийн тулд бид Тогтвортой байдлыг үндсэн бизнестээ нэгтгэсэн (тайлангийн “Үнэт зүйлс” хэсгээс үзнэ үү).

Бид Монгол дахь түншүүддээ хариуцлагатай компани, сайн хөрш байхыг эрмэлздэг бөгөөд багаа аюулгүй байлгаж, хүрээлэн буй орчныг хамгаалах, орон нутагтаа дэмжлэг үзүүлэх арга замаар үйл ажиллагаагаа явуулж, хайгуул хийхийг зорьдог.

Манай Тогтвортой байдлын бодлого нь тогтвортой өсч хөгжих, үйл ажиллагаагаа явуулах тодорхой зорилт, арга хэмжээнүүдийг тодорхойлсон. Бид аюулгүй, эрүүл үйл ажиллагаа явуулах, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, олон нийт, засгийн газартайгаа бат бөх харилцааг хөгжүүлэх, хадгалах, ил тод, ёс зүйтэй ажиллахыг зорьдог.

Манай Тогтвортой байдлын бодлогыг www.xanadumines.com вэбсайтаас үзнэ үү.

Тогтвортой байдлын бодлого

Занаду компани нь тогтвортой хайгуулын шилдэг компани байхыг эрмэлздэг.



Зорилтууд

Занаду Майнз компанийн тогтвортой байдлын зорилгууд:

Аюулгүй, эрүүл
үйл ажиллагаа

Байгаль орчинд үзүүлэх
нөлөөллийг багасгах

Орон нутгийн иргэд, засгийн
газартай бат бөх харилцааг
хөгжүүлэн, хадгалах

Ёс зүйтэй, ил тод байдлыг ханган үйл
ажиллагаа явуулах

Арга хэмжээ

Тогтвортой байдлын зорилгоо биелүүлэхийн тул Занаду дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг:

- Эрүүл, аюулгүй ажлын орчинг бүрдүүлэхийн тулд бүх оролцогч талуудыг татан оролцуулах.
- Хүн бүр аюулгүй, үнэ цэнэтэй, дэмжлэгийг мэдэрдэг, олон талт, хүртээмжтэй ажлын байрыг бий болгох.
- Үндсэн болон гэрээт ажилтнууд, ханган нийлүүлэгч, олон нийтийн гишүүдийнхээ хүний эрхийг хүндэтгэж, хамгаалах.
- Зөв хүмүүсээр багаа бүрдүүлэх, тэднийг тогтвортой ажиллуулахын тулд орон нутгийг төлөөлөх ажиллах хүчнээ бүрдүүлэх.
- Үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдийн эрх, хүсэл эрмэлзлийг дэмжиж, хүндэтгэлтэй байдлаар ашиг тус өгөх, хувь нэмэр үзүүлэх.
- Орон нутгийн иргэдийн соёлын өв, ёс заншил, уламжлалыг эрхэмлэн дээдлэх.
- Орон нутгийн төрийн байгууллага, олон нийттэй нээлттэй, шударга, тогтмол харилцаж, шийдвэр гаргахдаа тэдний санаа бодлыг харгалзан үзэх.
- Аюулгүй, үр ашигтай, тасралтгүй сайжруулах замаар үнэ цэнийг оновчтой болгохын тулд ханган нийлүүлэгчидтэй харилцаа холбоог бий болгох.
- Бизнесийн ёс суртахууны хэм хэмжээг сахиж, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт хууль ёсны шаардлагыг дагаж мөрдөх.

- Эрчим хүч, усыг үр ашигтай ашиглах, хог хаягдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэж буй ялгаралтыг зохицуулах, эрсдэл, боломжийг тодорхойлох, удирдах үйл явцыг бий болгох.
- Орон нутагт чиглэсэн үр дүнтэй төлөвлөлт, байгаль орчны менежментийг хэрэгжүүлж биологийн олон төрөл байдлыг хамгаалахад хувь нэмэр оруулах.
- Тогтвортой байдлын гүйцэтгэлийг олон нийтийн зорилт, зорилгод нийцүүлэн хянах, хэмжих, тайлагнах, баталгаажуулах.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр бид бизнес эрхлэх зөвшөөрлөө хадгалж, үйл ажиллагаагаа сайжруулна.

Занаду компани нь тогтвортой байдлын бодлого, үнэлгээний аргазүйг Олон улсын уул уурхай, металлын зөвлөлийн (ICMM) Уул уурхайн 10 зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Тогтвортой байдлын эрсдэлийг удирдахын тулд бид Эрсдлийн удирдлагын тогтолцоогоо хэрэгжүүлэх болно.

Дээрх бодлого, болон вэб сайтад байгаа Занаду компанийн бусад бүх бодлого, дүрэм, журмыг компанийн бүх үндсэн болон гэрээт ажилчид, ханган нийлүүлэгчид уншиж танилцан хэрэгжүүлдэг.

Ёс зүйтэй, ил тод байдлаар үйл ажиллагаа явуулах

Занаду компани нь бизнесээ тогтвортой, ашигтай байлгах зорилгын хүрээнд бүх оффисууд, уурхайн талбарт бизнесийн ёс зүйн хэм хэмжээг баримталдаг.

Бид компанийхаа байр суурийг Ёс зүйн дүрэм болон Тогтвортой байдлын бодлогодоо тодорхой тусгасан. Манай бүх ажилтан, гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид манай ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх ёстой ба доорх зүйлсийн хүрээнд заавал дагаж мөрдөх ёстой шаардлагууд орсон байдаг:

- Ёс зүйтэй бизнес (хээл хахууль, авлигын эсрэг);
- Хөдөлмөр эрхлэлтийн зарчим (тэгш боломж, ялгаварлан гадуурхалгүй, дарамтлах, доромжлох зан үйлээс ангид байх гэх мэт);
- Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал;
- Олон нийт ба хүрээлэн буй орчин.

Ёс зүйн дүрмийг www.xanadumines.com сайтаас үзнэ үү.

Ёс зүйн дүрмийн дагуу Занаду компани нь авлига, хээл хахуулийн эсрэг бодлогын (манай вэб сайтаас үзэх боломжтой) хүрээнд бизнесийн ёс суртахууныг баримталдаг.

Энэхүү Бодлогын зорилго нь Занаду компанийн оролцогч талуудын ашиг сонирхол, компанийн нэр хүндийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, Занаду компани болон түүний хяналтад байдаг байгууллагуудын (Занаду эсвэл Компани) хээл хахууль, авлигын талаарх байр суурийг тодорхойлдог.

Энэ нь Занаду компанийн бизнесийг ёс зүйтэй, шударгаар явуулах амлалтыг сахин биелүүлэхэд компанид болон компанитай хамтран ажилладаг хүн бүрийн үүрэг хариуцлага гэж тодорхойлсон байдаг. Энэхүү бодлого нь хээл хахууль, авлигын асуудлыг хэрхэн таних, хэрхэн шийдвэрлэх талаар мэдээлэл, зааварчилгааг өгдөг.

Энэхүү бодлого нь Занаду компанийн бүх удирдлага, ажилчид, гэрээлэгч, төлөөлөгчид, зөвлөхүүд болон Занаду компанийн нэрийн өмнөөс бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг эсвэл Занаду компанийн бүтээгдэхүүнийг түгээгч гуравдагч этгээдэд (нийлүүлэгч, борлуулагч, зөвлөх гэх мэт) бүгдэд үйлчилнэ.

100%

Компанийн бүх ажилтнууд 100 хувь авлига хээл хахуулийн эсрэг бодлоготой танилцан даган мөрддөг.

Авлига, хээл хахуулийн эсрэг бодлогын гол зарчмууд:

- Занаду компани нь бизнесийг ёс зүйтэй, шударгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Занаду нь авлига, хээл хахуулийн эсрэг хатуу соёлыг төлөвшүүлэхийн төлөө ажилладаг. Занаду компани нь гуравдагч этгээдтэй харилцахдаа хамгийн дээд түвшний шударга байдлыг баримталдаг.
- Занаду компани нь дэлхийн зах зээлд хүчтэй өрсөлдөгчийн хувиар хээл хахууль болон бусад авлигын үйлдэлгүйгээр оролцохыг эрмэлздэг.
- Занаду компани нь ажилчдынхаа болон аливаа гуравдагч этгээдийн хээл хахууль, авлигын үйлдлийг үл тэвчдэг ба тус бодлогыг зөрчсөн аливаа үйлдлийг ноцтой хэрэг гэж үзэж, хөдөлмөрийн болон бусад гэрээг цуцлах зэрэг сахилгын шийтгэл ногдуулдаг.

Занаду орчин үеийн боолчлол, хөдөлмөрийн мөлжлөгийн асуудалд нухацтай хандаж, нийлүүлэлтийн сүлжээнд ийм зүйл тохиолдохгүй байхын тулд арга хэмжээ авдаг.

Бид өрөмдлөг, геофизикийн судалгаа, үндсэн шинжилгээний үйлчилгээгээ Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн урт хугацааны харилцаатай Монгол Улсын ханган нийлүүлэгч байгууллагуудаас авдаг. Цаашид Занаду компани ханган нийлүүлэгчидтэйгээ тэдний нийлүүлэлтийн сүлжээг ойлгохын тулд үргэлжлүүлэн хамтран ажиллаж, орчин үеийн боолчлолын эрсдлийг бууруулах, энэ талаарх ойлголтыг хөгжүүлэхэд хамтран ажиллах болно.

Ёс суртахуунтай бизнес эрхлэхийн зэрэгцээ бид аль болох гол оролцогч талуудтайгаа шууд ил тод аргаар харилцахыг хичээдэг. Дээрх аргуудаас дурдвал: нүүр тулсан хэлэлцүүлэг уулзалт; зохицуулалтын тайлан; ажилчдад болон иргэдэд зориулсан танилцуулга уулзалт; газар дээр очиж уулзаж танилцах; гэрээ хэлцэл; салбарын уулзалт болон арга хэмжээ зохион байгуулах зэрэг орно.

Бидний гол оролцогч талуудтай хамтран ажиллах арга зарчмуудын бүрэн жагсаалтыг “Оролцогч талуудтай хамтран ажиллах” хэсгээс харна уу.



Тогтвортой байдлын ТОГТОЛЦОО

Занаду компани уул уурхайн хөгжүүлэлтийн бүх үе шатанд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусгах шаардлагатай гэж үздэг. Хайгуулын компанийн хувьд бид тогтвортой байдлын зарчмуудыг хайгуулын одоогийн үйл ажиллагаа, цаашдын үйл ажиллагаанд төсөл бэлтгэхийн тулд хийж буй судалгаандаа тусгадаг.

Бид компанийнхаа алсын хараа, хэтийн зорилгыг олон улсын тогтолцоо, жишиг үзүүлэлттэй уялдуулан тодорхойлдог.

НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилт

Занаду компани НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (SDGs) тууштай дэмждэг. Эдгээр зорилтуудад хүрэхэд хувь нэмэр оруулах байдлаар хамгийн гол асуудлуудыг тус тайланд төлөвлөн оруулав (17-р хуудсыг үзнэ үү). Бид эдгээр зорилтуудыг цаашдын стратегийн төлөвлөлт бодлогодоо тусгахаар ажиллаж байна.



Олон улсын Уул Уурхай, Металлын Зөвлөл

Занаду компани нь Олон улсын Уул Уурхай, Металлын Зөвлөлийн (ICMM) Тогтвортой хөгжлийн тогтолцооны стандартуудыг баримтлан тогтвортой байдлын гүйцэтгэлийг ICMM-ийн 10 зарчимд нийцүүлэхийг зорьж ажилладаг. Доорх хүснэгтээс тойм мэдээллийг харна уу.



ICMM зарчим	Бидний зорилт	Хуудас
1-р зарчим Бизнесийн ёс зүйтэй үйл ажиллагаа, компанийн засаглал, ил тод байдлын зөв тогтолцоог хэрэгжүүлэх.	Занаду компанийн ёс зүйн дүрэм болон авлига хээл хахуулийн эсрэг бодлого нь ёс зүйтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэлтийг зохицуулдаг. Шинээр ажилд орж буй ажилтан бүр сургалтанд хамрагдаж дүрэм журамтай танилцдаг.	Тогтвортой байдлын засаглал (хуудас 20)
2-р зарчим Тогтвортой хөгжлийг компанийн стратеги болон шийдвэр гаргах үйл явцад нэгтгэх.	Тогтвортой хөгжлийг компанийн шийдвэр гаргах үйл явцад нэгтгэсэн ба ТҮЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд байгаль орчны хороо, Аудит, эрсдэлийн хороо нь зохицуулан удирддаг. Тогтвортой байдлын бодлогын баримт бичиг компанийн гол зорилго, зорилтууд тусгагдсан.	Тогтвортой байдлын бодлого (хуудас 29)
3-р зарчим Явуулж буй үйл ажиллагаанаас хамаарч хүн бүрийн хүний эрх, соёл, зан заншил, үнэт зүйлс, ашиг сонирхлыг хүндэтгэх.	Хүний эрхийг эрхэмлэх, соёл, үнэт зүйлсийг хүндэтгэх зэргийг Занаду компани нь орон нутгийн иргэдийг дэмжиж хамтарч ажиллах, малчин, айл өрхүүдийн усны хангамж, оюутны тэтгэлэгт дэмжлэг үзүүлэх гэх зэрэг төслүүдээр дамжуулан биелүүлдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг 45, 51, 53 дугаар хуудаснаас харна уу.	Байгаль орчныг хайрлан хамгаалах: орон нутгийн иргэдийг дэмжих (хуудас 42, 48)
4-р зарчим Шинжлэх ухаан, өгөгдөл мэдээлэлд суурилсан эрсдэлийн удирдлагын үр дүнтэй стратеги, тогтолцоог хэрэгжүүлэх.	Занаду компанийн Эрсдэлийн удирдлага, Тогтвортой байдлын бодлогын хүрээнд ТҮЗ-ийн доорх Аудит, Эрсдэлийн дэд хороо нь эрсдэлийн удирдлагыг зохицуулан хэрэгжүүлдэг.	Тогтвортой байдлын засаглал (хуудас 20)
5-р зарчим Эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах.	Тогтвортой байдлын бодлого болон бусад холбогдох стандартыг Занаду компанийн ТҮЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны дэд хороо нь удирдан хэрэгжүүлдэг.	Аюулгүй ажлын байрыг бий болгох (хуудас 38)
6-р зарчим Байгаль орчны гүйцэтгэлийн асуудлуудыг тасралтгүй сайжруулахыг эрмэлзэнэ.	Занаду компанийн ТҮЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны дэд хороо нь байгаль орчны гүйцэтгэлийг компанийн Тогтвортой байдлын бодлого болон бусад холбогдох стандартуудын хүрээнд хүрээлэн буй орчинд үлдэх ул мөрийг бууруулахад удирдан хэрэгжүүлдэг.	Байгаль орчныг хайрлан хамгаалах (хуудас 42)
7-р зарчим Биологийн олон янз байдлыг хамгаалах, газар ашиглалтын төлөвлөлтийн нэгдсэн арга барилд хувь нэмэр оруулах.	Занаду компани хуурай газар дээрх амьдрал, ургамал амьтан, төрөл зүйлийг хүндлэн нөлөөллийг бууруулж байгаль орчны стандартыг баримтлан ажилладаг.	Байгаль орчныг хайрлан хамгаалах (хуудас 42)

ICMM зарчим	Бидний зорилт	Хуудас
8-р зарчим Металл, ашигт малтмал агуулсан бүтээгдэхүүнийг хариуцлагатай загварчлах, ашиглах, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах мэдлэгийн бааз, системийг хөнгөвчлөх, дэмжих.	Занаду компани нь бүтээгдэхүүнийхээ цаашдын хөгжилд зориулсан хамрах хүрээний судалгаандаа нөөцийг дээд зэргээр дахин ашиглах, хог хаягдлыг багасгах, хаягдлыг хариуцлагатай устгах зорилгоор технологийн процессын аюулгүй байдал, орчин үеийн малталтын үйл ажиллагаа, боловсруулалтын системийг тусгадаг.	Уур амьсгалын өөрчлөлт (хуудас 32)
9-р зарчим Үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгууллагын хөгжилд хувь нэмэр оруулах.	Занаду компани нь орон нутгийн иргэд, удирдлагатай тогтмол харилцаж хамтарч ажиллан тэдний нийгэм, эдийн засаг, байгууллагын хэрэгцээ шаардлагыг ойлгон, дэмжиж, аливаа боломжийг эрэлхийлж, урт хугацааны хөгжлийн боломж, ирээдүйн өсөлтөд хувь нэмэр оруулахыг эрмэлздэг.	Орон нутгийн иргэдийг дэмжих (хуудас 48)
10-р зарчим Нээлттэй, ил тод байдлаар гол оролцогч талуудыг идэвхтэй оролцуулж, ахиц дэвшил, гүйцэтгэлийг үр дүнтэй тайлагнаж, бие даан шалгах механизмыг бүрдүүлэх.	Тогтвортой байдлын бодлоготойгоо уялдуулан оролцогч талуудтай байнгын хамтын ажиллагаа үүсгэх замаар аюулгүй, эрүүл ажлын нөхцлийг бий болгож ажилладаг. Оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг ойлгосноор бидний бизнес болон орон нутгийн иргэдийн өсөлт хөгжил дээшилдэг.	Тайлангийн танилцуулга (хуудас 14)

Хүснэгт 3: Занаду компанийн Олон улсын Уул Уурхай, Металлын Зөвлөлийн тогтвортой хөгжлийн зарчмуудад нийцсэн байдал.

Олон Улсын Тайлангийн Санаачлага

Занаду компани анхны Тогтвортой байдлын тайланг бэлтгэхдээ Олон Улсын тайлангийн санаачлагын (GRI) стандартыг харгалзан үзсэн болно. Бид өөрсдийн бизнест мөрдөгдөж буй стандартыг олон улсын стандарттай нийцүүлэхээр ажиллаж байгаа ба дараа дараагийн тайланд ил тод байдлыг хангах болно.



Уур амьсгалын өөрчлөлт

Занаду компани нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах Парисын Конвенцийн зорилтыг дэмждэг ба дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад уул уурхайн салбар чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрч нэгдэж ажилладаг.

Хайгуулын компанийн хувьд бид харьцангуй бага хүлэмжийн хий ялгаруулдаг. Гэсэн хэдий ч бидний илрүүлсэн ордуудыг бусад уул уурхайн туршлагатай компаниуд цаашид хөгжүүлэн уур амьсгалын нөлөөллийг нэмэгдүүлнэ. Иймд бид эхний шатны судалгаануудаараа орчин үеийн, эрчим хүчний хэмнэлттэй уурхай байгуулах суурийг тавьдаг.



Бид технологийн шинэчлэл, үр ашигтай тоног төхөөрөмжөөр дамжуулан өөрсдийн эрчим хүчний зарцуулалтыг бууруулахаас гадна эрчим хүч бага зарцуулдаг технолог, дизайныг төслүүдийнхээ концепцийн судалгаанд нэгтгэн оруулах замаар бусад байгууллагын ирээдүйн хүлэмжийн хийн ялгарлыг багасгахад нөлөөлөхийг зорьж байна.

Шинэ технолог, дизайныг ашигласнаар бидний илрүүлсэн ордууд төлөвлөлтийн эхний үе шатнаасаа эхлэн нүүрстөрөгчийн хий багатай уул уурхайн шинэ төслүүд болоход бэлтгэгдэж байна.

Манай компанийн Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого нь түүний нөлөөллийг бууруулахад чиглэсэн бидний зорилго, үйл ажиллагааг тодорхойлдог.

Тус бодлогын хүрээнд бидний тавьсан зорилтууд:

- Эрчим хүчний хэрэглээ болон хүлэмжийн хийн ялгарлын талаар ил тод мэдээлэх, тайлагнах;
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах боломжийг эрэлхийлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэл, боломжуудыг бизнесийн шийдвэрийн нэг хэсэг болгон авч үзэх.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх бидний байр суурийн талаар дэлгэрэнгүйг доорх Бодлогын баримт бичгээс эсвэл www.xanadumines.com сайтаас үзнэ үү.

Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого

Занаду Майнз нь дэлхийн хэмжээний зэс-алтны ордуудыг тогтвортой илрүүлэх, тодорхойлох, хөгжүүлэхийн төлөө ажилладаг.

Уур амьсгалын өөрчлөлт нь биднээс уур амьсгалд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлж, үнэлж, тайлагнаж байхыг шаарддаг бөгөөд өнөөдөр дэлхий нийтэд тулгарч буй хамгийн чухал сорилтуудын нэг юм.

Бид уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголтыг хүлээн зөвшөөрч, Парисын хэлэлцээрийн зорилтуудыг дэмжиж, дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад уул уурхайн салбар чухал үүрэгтэй гэдгийг ойлгодог.

Занаду компани нь уур амьсгалын өөрчлөлт болон эрчим хүчний хэрэглээг тооцоолон тодорхойлж, стратеги төлөвлөлтдөө тусгах шаардлагатай гэж үздэг. Иймд засгийн газар, хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид, даатгагчид, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, орон нутаг, салбарын холбоод зэрэг оролцогч талуудтай хамтран ажиллаж хүлэмжийн хий бага ялгаруулдаг эдийн засгийг бий болгоход хувь нэмэр оруулах стратеги боловсруулна.

Хамрах хүрээ

Энэхүү бодлого нь Занаду компанийн бүх үйл ажиллагаа, хайгуулын төслүүдэд хамаарна.

Зорилтууд

Занаду Майнзийн зорилт:

- Эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийг ил тод тайлагнана,
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах бүхий л боломжийг эрэлхийлнэ,
- Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл болон бууруулах боломжийг бизнесийн шийдвэр гаргалтанд тусгана.

Авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа


- Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, боломжуудыг тодорхойлж, удирдахыг эрэлхийлж, хувьцаа эзэмшигчдэдээ тогтвортой өндөр ашиг өгөөж өгөх зорилгод нийцүүлэн ажиллах.
- Засгийн газар, хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид, даатгагчид, үйлчлүүлэгчид, олон нийт зэрэг оролцогч талуудын хэрэгцээг хангахын тулд гүйцэтгэлийн хэмжүүр, зорилтуудын уур амьсгалын өөрчлөлтийн ил тод тайланг боловсруулах.
- Олон улсын тогтвортой байдлын стандартад нийцсэн эрчим хүчний хэрэглээ болон хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжих, баталгаажуулах аргыг ашиглах.
- Хүлэмжийн хийн ялгарлын эрчмийг бууруулахын тулд сэргээгдэх эрчим хүч, бага ялгаруулдаг эрчим хүчний технологийн хэрэглээг нэмэгдүүлэх хувилбаруудыг идэвхтэй үнэлнэ.
- Ирээдүйн эрчим хүчний үнэд нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлтийн хувилбаруудыг үнэлж, нүүрсхүчлийн хийн зардлыг бизнесийн шийдвэрт тусгана.
- Одоогийн болон төлөвлөж буй төслийн байршилд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй болзошгүй аюулыг тодорхойлохын тулд мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, тэсвэрлэх чадварыг бий болгохын тулд зохих арга замаар хөрөнгө оруулалт хийх.
- Хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх тогтвортой, урьдчилан таамаглахуйц зохицуулалтын дэглэмийг дэмжихийн тулд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн бодлого боловсруулах үйл явцад бүтээлчээр хувь нэмрээ оруулж, салбарын байгууллагууд болон засгийн газруудтай туршлагаа хуваалцана.

Бодит жишээ

Хармагтайн судалгааны технологийн онцлог

Хармагтай ордын хамрах хүрээг тодорхойлох судалгаагаар Занаду компани нь төслийг эрчим хүчний хэмнэлттэй, аюулгүй, арилжааны хувьд ашигтай байлгах үүднээс орчин үеийн шинэлэг технолог, туршлагыг ашиглан загварчлан бүтээж байна. Эдгээрээс онцолвол:

- Хөдөлгөөнт цахилгаанжуулалт: бүрэн цахилгаанжуулсан хөдөлгөөнт флот нь газар доорх дизель түлшний тоосонцорын эрсдэлийг эрс бууруулж, дулаан үйлдвэрлэх, хөргөх хэрэгцээг бууруулдаг;
- Конвейерийн тээвэрлэлт: бүтээгдэхүүн материалыг гадаргуу руу зөөвөрлөхөд конвейер ашиглах нь дизель тоног төхөөрөмжийг сольж, тоосонцорыг цаашид багасгаж, тээвэрлэлтийн замын хөдөлгөөнийг зогсоох замаар аюулгүй байдлыг сайжруулж, уурхайн томрох, өөрчлөгдөхөд цар хүрээг тэлсэн шийдэл юм;
- Орчин үеийн малталт: блокоор ухах нь олборлосон тонн тутамд эрчим хүчний зарцуулалтыг бууруулж, эрсдэл өндөртэй орчинд ажиллагсдын тоог бууруулдаг;
- Газар доорх баяжуулалт: гадаргуу руу зөөх материалын хэмжээг багасгах замаар газар доорх материалыг бутлах, ангилах нь эрчим хүчний хэрэгцээг бууруулдаг;
- Газрын гадаргад баяжуулах: гадарга дээр ангилах дараагийн үе шат нь тээвэрлэх байгууламжаар бага материал дамжих тусам эрчим хүчийг илүү багасгаж, нөхөн сэргээх хаягдлыг бууруулдаг;
- Ногоон эрчим хүч: Монголын нар, салхины цэвэр эрчим хүч нийлүүлэгчдийг нэгтгэн дэмжсэн цахилгаан эрчим хүчний гэрээг ашиглан орон нутгийн нүүрсний цахилгаан станцуудын эрэлтээс үүдэлтэй хоёрдогч ялгаралтыг бууруулах;
- Төмөр замын тээвэр: Хармагтайгаас 7 км-ийн зайд Монголын төмөр замын суурь бүтцийг ашиглах нь эрчим хүчний бага эрчимтэй баяжмалыг тээвэрлэх боломжийг олгож, зам дээрх холын даацын ачааны машины тоог бууруулдаг.



Stockwork Hill дэх концепцийн судалгааны ил уурхай болон блок малталтын зураг төсөл

17

Өрөмдсөн метр
тутмын литр
дизель түлш*



*2020 онд ашигласан 528,000 литр
дизель түлшинд үндэслэн тооцов.

Аюулгүй ажлын байрыг дэмжих



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Занаду компани нь бүх хүмүүстээ эрүүл, аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэхийн төлөө ажилладаг.

Занаду компанийн үндсэн болон гэрээт ажилчид компанийн ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай бүхий л хууль тогтоомж, бодлого, журмыг дагаж мөрдөн, аюулгүй, эрүүл мэндэд эрсдэлгүй орчинд ажиллаж байгаагаа баталгаажуулах шаардлагатай.

Аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх бидний байр суурийг Тогтвортой байдлын бодлогод тусгасан. Бодлогын хүрээнд бид:

- Аюулгүй, эрүүл ажлын орчныг бүрдүүлэхийн тулд бүх оролцогч талуудыг татан оролцуулах.
- Хүн бүр аюулгүй, үнэ цэнэтэй, дэмжлэгийг мэдэрдэг олон талт, хүртээмжтэй ажлын байрыг бий болгох.
- Үндсэн болон гэрээт ажилтан, ханган нийлүүлэгч, олон нийтийн гишүүдийнхээ хүний эрхийг хүндэтгэж, хамгаална.

Занаду компанийн Тогтвортой байдлын бодлогыг www.xanadumines.com сайтаас үзнэ үү.

O

Хөдөлмөрийн чадвар алдахад хүргэсэн гэмтэл



Бодит жишээ

Занаду компанийн COVID-19 цар тахлын үед ажилчдаа хамгаалах бодлого

COVID-19 цар тахлын нөлөөлөл Монгол Улсад төдийгүй олон улсын хэмжээнд урьд өмнө тохиолдож байгаагүй билээ. Занаду компани нь Хармагтай болон Улаан уулын төслүүд дээрх хүний нөөцийн аюулгүй байдлыг хангахын тулд холбогдох эрсдэл, тогтоосон дүрэм журмыг мөрдөн ач холбогдол өгч ажилласан.

Царт тахлын нөлөө 2020 оны 10-р сард мэдрэгдэж, орон нутгийн иргэдийн дунд халдвар дамжиж эхэлсэн байна. Занаду компанийн үйл ажиллагааны баг ажиллах хүчний халдвар дамжих эрсдэлийг бууруулах хоёр үе шаттай төлөвлөгөөг нэн даруй боловсруулсан болно.

1-р үе шатны хүрээнд талбарыг “ногоон бүс” байлгах үүднээс эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл бууруулах хяналтыг хийсэн. Үүнд талбарт гадны хүн нэвтрэх эрхийг хаах (жишээ нь орон нутгийн иргэдээс), ажиллах хүчний зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, аялж буй хүмүүсээс эрүүл мэндийн асуумж авах, талбарын эрүүл ахуй, ариун цэврийн арга хэмжээг сайжруулах, талбар луу нэвтрэх хүн бүрийг ПГУ-ын шинжилгээнд хамруулах зэрэг багтсан. Үүний үр дүнд халдварыг барьж чадсан.

Харамсалтай нь 2021 оны 3-р сард орон нутгийн зарим хязгаарлалтыг цуцалсны улмаас улсын хэмжээний халдварын тоо нэмэгдэж, Занаду компани яаралтай, хатуу арга хэмжээ авахаас өөр аргагүй болсон. Энэ нь 2-р үе шат хэлбэрээр явагдсан бөгөөд үйл ажиллагааны удирдлагын баг ажилчдаа вакцинжуулах ажлыг эрчимжүүлсэн.

Хармагтай дахь талбарт (Улаан уулд 2020 оны 11-р сараас 2021 оны 2-р сарын хооронд 2-р шатны үйл ажиллагаа хэрэгжсэн) ажилчдын вакцинжуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн эмнэлгүүдийг татан оролцуулсан.

2021 оны 5-р сарын 1-нээс эхлэн вакцинжуулалтын эхний тунг аваагүй хүнийг (2021 оны 6-р сарын 1-ээс эхлэн бүрэн вакцинжаагүй хүнийг) талбарт оруулахгүй байх тухай шинэчлэн боловсруулсан бодлогыг чанд мөрдөж, хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэв.

Үүний үр дүнд 2021 оны 6-р сард талбарт ажиллаж байсан гэрээт ажилтны тусгаарлалтын хугацаанд өгсөн шинжилгээний хариу эерэг гарсан ч нийт ажилтан, бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангаж чадсан байна. 2021 оны 6-р сарын байдлаар нийт үндсэн болон гэрээт ажилтнууд 100% вакцинд бүрэн хамрагджээ.



Бодит жишээ

Байгууллагын соёл, гүйцэтгэлийг сайжруулах аюулгүй байдлын шинэ санаачлага

Манай байгууллагын ажилтнууд болон орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал бидэнд хамгаас чухал.

Бид сургалтыг сайжруулах, системийг хөгжүүлэх замаар ажлын талбар дээрх аюулгүй байдлын соёлыг тасралтгүй сайжруулж, аюулгүй байдлын санаачлагыг үргэлжлүүлэн тодорхойлж байна (жишээлбэл, аюулгүй байдлын шалгалтын тайланг удирддаг шинэ i-auditor системийг нэвтрүүлсэн).

Сурах арга, чадварыг сайжруулах зарим аргууд:

- Үйл ажиллагаа, гол талбар, геологийн ач холбогдол гэх гурван зүйлээр гүйцэтгэлийг хянан аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн шат шатны үйл ажиллагаанд үзүүлсэн хүчин чармайлтыг үнэлж, аюулгүй байдлын шагнал олгов.
- Ажил горилогчдыг бүс бүрээс сонгон шалгаруулж, тусгай сургалтанд хамруулж, тухайн бүс нутагтаа аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийг удирдан чиглүүлэхээр аюулгүй ажиллагааны дадлагажигчаар томилов.
- Сар бүрийн аюулгүй байдлын сэдвүүдийг танилцуулж, мэдлэгээ хуваалцахыг дэмжих зорилгоор багуудаар хэлэлцүүлэв.



1.58

* Хөдөлмөрийн чадвар алдах осол гэмтлийн давтамж нь нийт бүртгэгдэж болох гэмтлийн давтамжийн хувь (200,000 өртөлтийн цаг тутамд бүртгэгдэх нийт гэмтлийн тоо юм. Нийт бүртгэгдэж болох гэмтэлд эмнэлгийн эмчилгээ хийлгэсэн гэмтэл, ээлжийн /хязгаарлагдмал ажлын гэмтэл, цаг алдсан гэмтэл, нас баралт багтана. Энэ тооцоо нь нэг эмнэлгийн тусламж авсантай холбоно).

Хөдөлмөрийн чадвар алдах
осол гэмтлийн давтамж *
200,000 цагаар

Байгаль орчноо хайрлан хамгаалах

Байгаль орчны удирдлага

Занаду компанийнхан үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдийн амьжиргаанд чухал нөлөөтэй орон нутгийн байгаль орчинд хүндэтгэлтэй хандаж, хайрлан хамгаалдаг.

Бид орон нутгийн бүх хууль тогтоомжийг дагаж мөрддөг бөгөөд үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй байгаль орчны эрсдэлийг тодорхойлохын зэрэгцээ байгаль орчинд ээлтэй байдлаар бизнес эрхлэхийг эрмэлздэг.

Бид Тогтвортой байдлын бодлогоор дамжуулан байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах үүрэг хүлээдэг. Ингэхдээ бид:

- Эрчим хүч, усыг үр ашигтай ашиглах, хог хаягдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэж буй ялгаралтыг зохицуулах эрсдэл, боломжийг тодорхойлох, удирдах тогтолцоог бий болгоно.
- Бидний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн орон нутагт үр дүнтэй төлөвлөлт, байгаль орчны менежментийг хийснээр биологийн олон янз байдлыг хамгаалахад хувь нэмэр оруулна.



12,404

Занаду компанийн эзэмшиж
буй газар (га)



Усны менежмент

Бидний үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын тухайн газарт орон нутгийн иргэдийн ундны усны авч ашиглах боломж хязгаарлагдмал байна.

Бид орон нутгийн иргэдийг гүний усаар хангахын тулд өрөмдлөгийн ажилд дэмжлэг үзүүлж, сургалт явуулдаг.

Ус бол Монгол орны үнэт баялаг гэдгийг бид мэднэ. Байгаль орчны менежментийн стандартад заасны дагуу бид усаа хариуцлагатай, үр дүнтэй ашигладаг.

Бид өрөмдлөгийн гүйцэтгэгчийн гэрээнд бохирдсон ус асгарахаас урьдчилан сэргийлэх, бохирдуулахаас сэргийлэх цөөрөм эсвэл хаалт байгуулахад зөвлөгөө дэмжлэг үзүүлдэг. Бид өөрсдийн үйл ажиллагааны улмаас газрын

доорх усанд үзүүлж буй нөлөөллийг, түүнийг хэрхэн удирдаж байгааг ард иргэдэд үр дүнтэй танилцуулж, тулгамдаж буй аливаа асуудлыг шийдвэрлэхийн тулд нээлттэй яриа хэлэлцүүлэг хийж ажилладаг.



**2020 онд 11,548м³ гүний ус ашигласан тооцоонд үндэслэв.*

<0.5

Өрөмдсөн метр тутамд ашигласан гүний усны хэмжээ м³*

БОДИТ ЖИШЭЭ

Орон нутгийн иргэдийн гүний ус ашиглах боломж

Говийн усны нөөц бол маш хязгаарлагдмал нөөц юм.

Говь цөлд гол горхи байхгүй тул малчид гүний худгаас усаа авдаг.

Орон нутгийн иргэд ахуйн болон ундны усны хэрэглээ, мал (хонь, ямаа, адуу, тэмээ гэх мэт) услах зэрэг ахуйн чухал хэрэгцээгээ худгийн усаар хангадаг ба Занаду компани нь орон нутагт гүний худгийн хэрэгцээ шаардлага өндөр байгааг ойлгодог. Тиймээс орон нутгийн иргэдийн усны хүртээмжийг сайжруулах зорилгоор үйл ажиллагаа явуулж буй орон нутаг бүрт 100 метрийн гүний худгийг өрөмдөж гаргах ажлыг 2-3 жил тутам зохион байгуулж хийдэг.

Мөн гидрологийн судалгаа хийн усны чанарыг шалгаж, худгуудад стандарт хангасан дизель генератор эсвэл усны насос суулган ус гаргаж авдаг ба худгийн ажиллагаа, засвар үйлчилгээний ажлыг тогтмол хариуцан хийдэг.

Орон нутгийн иргэдийн санхүүгийн байдлыг дэмжих үүднээс худаг ажиллуулах, хянаж шалгах ажлыг орон нутгийн иргэдээс авч ажиллуулан цалинжуулдаг ба худгийн ажиллагааг хянах төхөөрөмжөөр хангасан.

Бид усны түвшин, агуулгыг хэрхэн хэмжих, шалгах талаар нутгийн иргэдэд сургалт явуулж, төхөөрөмжийг ашиглах заавар зөвлөгөө өгөхөөс гадна усан дахь уул уурхайн болон бусад үйл ажиллагаанаас үүдэлтэй химийн хорт бодисын агууламжийг тодорхойлохоор усны дээжийг лабораторид шинжлүүлдэг.

Занаду компани өөрийн үйл ажиллагаанд, ялангуяа өрөмдлөгийн үйл ажиллагаанд өөрийн үйлдвэрлэлийн зориулалттай худгийг ашигладаг. Усны нөөц ховор нөхцөл байдалд бид нутгийн ард иргэдийг ус олборлох ажилд оролцуулж бидний явуулж буй үйл ажиллагаа нутгийн иргэдийн гүний ус авах боломжид ямар нэг хүндрэл учруулдаггүй гэдгийг ойлгуулдаг.



Орон нутгийн иргэдийг худгийн усны гарцыг хэмжихэд сургадаг

Хуурай газар, биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг удирдах

Бид үйл ажиллагаа явуулж буй орон нутагт өөрсдийн хайгуулын үйл ажиллагааны нөлөөллийг багасгахыг хичээж ажилладаг.

Бид үйл ажиллагаа явуулахдаа Байгаль орчны удирдлагын стандартыг мөрдөн хэрэгжүүлж ажилладаг.

Манай стандарт нь газрын эвдрэлийг багасгах, нөхөн сэргээлтийг зохицуулах шаардлагыг тодорхой тусгасан байдаг. Үүнээс дурдвал:

- Дээж авах ажиллагааны явцад өнгөн хөрсөн дэх хөрс, ургамлыг салган авч, дээж авсны дараа буцаан байрлуулдаг;
- Дээж авах цэгүүдийг малд аливаа хор хөнөөл учруулахгүй байдлаар тэмдэглэдэг;
- Зөвхөн шаардлагатай үед суваг ухах ба хөрсөн бүрхэвчийг тусад нь хадгалдаг. Зураглал хийж, дээж авсны дараа сувгийг хааж, хөрсний давхаргаар хучиж, дахин ургамалжуулдаг.
- Налуу газарт хөрсний нуралт үүсэхээс хамгаалж урьдчилан сэргийлэх ус зайлуулах суваг гаргадаг,
- Талбайн үйл ажиллагааны дараа нэн даруй байгалийн төрөлх өвсний үр, ургамлаар буцаан нөхөн сэргээх арга хэмжээ авдаг.

Энэхүү стандартад нутгийн амьтан, ургамлын менежмент, орон нутгийн амьтадад (тэжээвэр болон зэрлэг) аливаа нөлөөгүй байх, урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр ургамлыг устгах, гэмтээхгүй байх замаар нутгийн ургамлын зүйлийн амьдрах орчныг хамгаалах зэрэг багтсан.

<1

Га газарт үйл
ажиллагаа
явуулсан

Орон нутгийн иргэдийг дэмжих

Занаду компани нь орон нутгийн иргэдтэй бат бөх харилцаа үүсгэж харилцан ойлголцож, нэгдсэн тогтвортой зорилгыг хэрэгжүүлэхийг эрмэлздэг.



Занаду компани бол орон нутгийн иргэд, ажилтнуудынхаа аж амьдралыг дэмжих үүрэг хүлээсэн хариуцлагатай байгууллага юм. Манай үйл ажиллагаанд оролцож буй хүн бүр холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх ёстой ба манай ажилтнууд орон нутгийн иргэдийн хөгжилд идэвхитэй хувь нэмрээ оруулдаг.

Тогтвортой байдлын бодлогын хүрээнд бид орон нутгийн иргэдээ дэмжиж ажилладаг. Тухайлбал:

- Ажилтан, туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид болон орон нутгийн иргэдийн хүний эрхийг хүндэтгэж, хамгаалах
- Зөв хүмүүсийг татах ажиллуулах, тэднийг тогтвортой ажиллуулах зорилгоор орон нутгаас ажиллах хүч бүрдүүлэх.
- Орон нутгийн иргэдийн эрх, хүсэл эрмэлзлийг хүндэтгэн дэмжиж, үр шимийг хүртээх.
- Орон нутгийн соёлын өв, ёс заншил, уламжлалыг эрхэмлэн дээдлэх.
- Орон нутгийн төрийн байгууллага, олон нийттэй нээлттэй, шударга, тогтмол харилцаж, шийдвэр гаргахдаа тэдний санаа бодлыг харгалзан үзэх.



Орон нутгийн иргэдийн санал гомдол




Эрүүл
мэндийг
дэмжих



Чанартай
боловсролыг
дэмжих



Баталгаат
ундны ус,
ариун цэврийн
байгууламжаар
хангах



Эдийн
засгийн өсөлт,
баталгаат
ажлын байрыг
бий болгох

Орон нутгийн иргэдийг сонсох, дэмжих

Занаду компани нь орон нутгийн иргэдийн санал гомдлыг сонсон хамтран ажиллаж сайн түншлэлийг бий болгодог

Бид үйл ажиллагааныхаа талаар орон нутгийн иргэдтэй нээлттэй, ил тод яриа хэлэлцээ өрнүүлэхийн төлөө тогтмол ажилладаг. Энэ бол хариуцлагатай компани байх үндэс суурь гэдэгт бид итгэдэг.

Бид орон нутгийн иргэдийг сонсож, тэдний хэрэгцээ, асуудлыг илүү сайн ойлгохыг эрмэлздэг.

Бид ажил эрхлэлт, орон нутгийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх, хандив, тэтгэлэг, орон нутгийн төрөл бүрийн хөтөлбөр хэрэгжүүлж, бизнес эрхлэлтийг дэмжих замаар орон нутгийн хөгжлийг дэмжин “сайн түнш” хэвээр байхыг эрмэлздэг. Энэ нь орон нутгийн засаг захиргааны шийдвэрийг ойлгож, дэмжсэний үндсэн дээр хийгдэнэ.



Бодит жишээ

Орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн хөгжил

Занаду компани орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг идэвхитэй дэмждэг

Сүүлийн гурван жилийн хугацаанд Занаду компани орон нутгийн засаг захиргааны дэмжлэгтэйгээр өрх толгойлсон эхчүүдийн ажиллуулдаг орон нутгийн жижиг оёдлын цехтэй гэрээ байгуулж, Хармагтай төсөлд ажлын хувцас, дээжний шуудай, чулуун дээжийг гадны нөлөөллөөс (тоос шороо, салхи) хамгаалах бат бөх дээжний бүтээлэг хучлага гэх мэт олон төрлийн бараа бүтээгдэхүүн захиалж нийлүүлсэн.

Энэ нь манай хайгуулын төслийн хувьд чухал үйлчилгээ бөгөөд чөмгөн дээжийг шинжилгээнд зориулж хадгалах явцад хамгаалах чухал ач холбогдолтой юм.

Занаду компанийн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих бусад санаачлагууд:

- Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт;
- Уламжлалт морин уралдаан болон орон нутгийн улирлын болон шашны баяр зэрэг соёлын үйл ажиллагааг дэмжих;
- Хүйтэн өвлийн дараа хүнс тэжээлийн нөөц шавхагдсан хаврын эхэн үед орон нутгийн айл өрхүүдэд эрүүл мэндийн дархлаажуулалтын витамины багц, малын тэжээл тараах, хандивлах;
- Орон нутгийн эмнэлгүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмж хандивлах. 2020 онд манай “Улаан уул” төслөөс орон нутгийн эмнэлэгт эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж (эм, вакцин хадгалах хөргөгч гэх мэт) хандивлаж, шинэ морг барихад дэмжлэг үзүүлсэн.



Улаан уул төсөл байрлах сумын эрүүл мэндийн төвд Занаду компанийн орон нутаг хариуцсан менежер Баттөр вакцин хадгалах хөргөгч хүлээлгэн өгч байна



Орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн үзлэг



Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалт

Занаду компани нь орон нутгийн иргэдэд ашиг тусаа өгөхийг эрмэлздэг ба нэн шаардлагатай чухал үйлчилгээ болон урт хугацааны хөрөнгө оруулалтыг тэнцвэртэйгээр, дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлэхийг зорьдог.

Суурин газраас алслагдсан орон нутгийнханд олон нийтийг дэмжих, хөгжүүлэх, тэдний богино хугацааны хэрэгцээг хангах нь нэн тэргүүний шаардлага байдаг боловч урт хугацааны үр өгөөжтэй боломжийг бидний тус орон нутагт явуулж буй үйл ажиллагаанаас хамааралгүйгээр хөгжихөд нэмэр болох хэлбэрээр олгох нь чухал.

Ийм урт хугацааны боломж бололцоог эрэлхийлж нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг судлан орон нутгийн удирдлага, иргэдтэй тогтмол бат бөх харилцаа хамтын ажиллагаатай байдаг.



Бодит жишээ

Боловсролоор дамжуулан орон нутгийн иргэдийг дэмжих

Боловсролын дэмжлэг, компаниас зарладаг тэтгэлэгт хөтөлбөр бол орон нутгийн иргэдийг дэмжих урт хугацааны хөрөнгө оруулалт юм.

Орон нутгаа хөгжүүлэхэд туслах чухал боломж бол эдгээр орон нутгийн залуучуудын боловсролыг дэмжих явдал гэж бид үздэг.

Залуу үеийнхний шинэ ур чадварыг хөгжүүлэхээр илүү өргөн боломжуудыг судлах, өмнө нь байгаагүй боломжийг бий болгох чухал ач холбогдолтой.

Занаду компани жил бүр хоёр төслийн орон нутгийн залуучуудыг дээд боловсрол эзэмшихэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэн тэтгэлэг олгодог. Оюутнуудыг анагаах ухаан, инженерчлэл, нягтлан бодох бүртгэл, байгаль орчны шинжлэх ухаан гэх мэт чиглэлээр хүссэн их дээд сургуульдаа суралцахад бид дэмжлэг үзүүлдэг.

2020 онд Занаду компани нь хоёр төслийн хүрээнд нийт 25 оюутныг их сургуульд элсэн суралцахад дэмжин тэтгэлэг олгосон байна. (Хармагтай төслөөс 15, Улаан уулын төслөөс 10).

Үүнээс гадна бид Занаду компанид туршлага хуримтлуулах болон ажил хайж байгаа хүмүүст дадлага хийх боломжийг олгодог. Бид орон нутгийн хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан орон нутгийнхаа эдийн засгийн хөгжлийг сайжруулахад туслахын тулд боловсролын дэмжлэгт хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлэн хийхээр зорьж байна.




График 1: 2018-2020 онд тэтгэлэг хүртсэн нийт оюутны тоо.

“

Занаду компани нь орон нутгийн ард иргэд болон ажилчдынхаа гэр бүлд санаа тавьдаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахын төлөө шаргуу ажилладаг хамт олон юм.

Бид орон нутгийнхаа хэрэгцээ, хүлээлтийг ойлгон ухамсарлаж, нийгэмдээ тогтвортой хөгжих боломжийг олгохын тулд засгийн газар, олон нийттэйгээ хамтран ажиллана.

Мөнхсайхан Дамбийням

Үйл ажиллагаа хариуцсан захирал

Байгууллагын удирдлага

ТУЗ-ийн гишүүд/Захирлууд

Колин Мурхэд

ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн

Эндрю Стюарт

CEO, Ерөнхий захирал

Ганбаяр Лхагвасүрэн

ED, Гүйцэтгэх захирал

Мишэл Мускило

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Тони Персон

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Компанийн нарийн бичгийн дарга

Фил Макей

Бүртгэлтэй хаяг – Авсртали улс

c/o Company Matters Pty Limited

Level 12, 680 George Street

Sydney NSW 2000

Утас: +61 2 8280 7497

Факс: +61 2 9287 0350

Бүртгэлтэй хаяг – Монгол Улс

Улаанбаатар 14240,

Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Олимпийн гупамж,

9Б Байр, 23 тоот

Утас: + 976 11 7012 0211

Хувьцааны бүртгэл

Computershare Investor Services Pty Limited

Level 3, 60 Carrington Street

Sydney NSW 2000

Утас: +61 1300 855 080

Аудитор

Ernst and Young

200 George Street

Sydney NSW 2000

Хөрөнгийн биржийн бүртгэл

Xanadu Mines Ltd компани Австралийн Үнэт

Цаасны Бирж болон Торонтогийн Хөрөнгийн

Биржид бүртгэлтэй (ASX and TSX code: XAM)

Веб хуудас

www.xanadumines.com

ABN

92 114 249 026

Байгууллагын засаглалын мэдээлэл

Байгууллагын засаглалын мэдээллийг

компанийн вэб хуудсаас үзэж болно:

www.xanadumines.com/site/about/corporate-governance



@XanaduMines_ASX



au.linkedin.com/company/xanadu-mines-limited

ЗАНАДУ МАЙНЗ

XANADU MINES

www.xanadumines.com



Биднийг *LinkedIn and Twitter* дээр дагаарай

